

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020.09.16

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 16:00-16:40 цагийн хооронд Хөнгөн бетон ХК-ийн захирлын өрөөнд хурлыг хийв.

Хуралд оролцсон:

1. Б.Наранзул - 72625
2. Б.Наранцацралт - 88577
3. “Минжит булган гол”ХХК /захирал Т.Баярхүү/ - 14918
4. Т.Баярхүү - 1034

Хурлын дарга Б.Наранзул хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав. Үүнд:

“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177154 ширхэг байгаа ба 99%-ийн ирцтэй байгаа тул хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг нээснийг мэдэгдэв.

Хурлын дэг, дарааллын дагуу ХЭ-ийн хурлаар доорхи асуудал танилцуулж хэлэлцэнэ:

- 1) “Хөнгөн бетон” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Шийдвэрлэсэн нь: Хурлын дараалал, дэгийг өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Асуудал 1. “Хөнгөн бетон” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Хурлын дарга Б.Наранзул:

“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан нийт 179373 ширхэг энгийн хувьцааны 6 хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байсан 177154 ширхэг саналын эрхтэй хувьцаанаас саналын эрхтэй 77148 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 43%-ийг төлөөлсөн 2 хувьцаа эзэмшигч болох Н.Эрдэмбилэг, Н.Эрдэмбаяр нар хувьцаагаа эргүүлэн худалдаж багцын арилжаа явагдсан бөгөөд нэгдмэл сонирхолтой этгээд хамтран саналын эрхтэй 99% эзэмшдэг болсон. Үүнд:

1. Б.Наранзул - 72625
2. Б.Наранцацралт - 88577
3. “Минжит булган гол”ХХК /захирал Т.Баярхүү/ - 14918
4. Т.Баярхүү - 1034

Иймд бид нэгдмэл сонирхолтой саналын эрхтэй 99% эзэмшиж байгаа тул хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож, компанийн хэлбэрийг өөрчлөх санал гаргаж байгаа тул хувьцаа эзэмшигчид саналаа хэлж, саналын хуудсаа бөглөнө үү.

Т.Баярхүү: 99%-ийн хувьцаа нэгдмэл сонирхолтой этгээдэд цугларсан тул ХХК болгоход татгалзахгүй, дэмжиж байна.

Б.Наранцацралт: Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохыг дэмжиж байна.

Хурлын дарга Б.Наранзул: Тооллогын комисс саналын хуудсуудыг авч нэгдсэн дүнгээ гаргаад саналын тоог танилцуулаарай.

Тооллогын комиссын дарга Н.Бүрэнжаргал: Саналын хуудсыг нэгтгэн тооллоо. Үүнд:

- 1) “Хөнгөн бетон” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэж баталахад саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн байна.

Б.Наранзул: За ингээд хэлэлцэх асуудал дууссан тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Ундрах

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Хувьцаа эзэмшигчид:

1. Б.Наранзул
2. Б.Наранцацралт
3. “Минжит булган гол” ХХК, /захирал Т.Баярхүү /
4. Т.Баярхүү

